**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2020 оны 03 сарын 20 өдөр Дугаар А/196 Улаанбаатар хот

Сүрьеэ өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 2 дугаар заалт, Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүрьеэ өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг нэгдүгээр, Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шалгуур үзүүлэлтийн биелэлтийг хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагуудад тайлагнаж байхыг Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), тайлагналтад хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Нийгмийн эрүүл мэндийн газар (Т.Энхзаяа)-т тус тус үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Нийгмийн эрүүл мэндийн газар (Т.Энхзаяа), Эрүүл мэндийн хөгжлийн төв (Д.Нарантуяа), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү)-д тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Я.Амаржаргал)-д үүрэг болгосугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

141200684

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын
20-ний өдрийн А/196 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## НЭГ. СҮРЬЕЭ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### 1.1. Сүрьеэ өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөний зорилго нь сүрьеэгийн халдварын тархалт, бүртгэгдсэн тохиолдлын мэдээг үнэн зөв, шуурхай байдлыг хангаж, үр дүнтэй цуглуулж, дүн шинжилгээ хийж, түгээснээр үндэсний хэмжээнд хийх хариу арга хэмжээг оновчтой болгох, нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргахад хувь нэмэр оруулахад оршино.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд дараах зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

- Хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг тодорхой болгосноор мэдээ цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, тайлбарлах үйл ажиллагааг сайжруулах;
- Үндсэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох;
- Сүрьеэгийн чиглэлээр үндэсний хэмжээнд хийгдэж буй судалгааны практик ач холбогдлыг дээшлүүлэх;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээнд шаардлагатай мэдээний эх үүсвэрийг тодорхойлох;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээнд оролцогч талуудын чадавхийг сайжруулах;
- Хэрэгжүүлэгч байгууллага, түншлэгч, хамтрагч байгууллагууд болон нийт хүн амд түгээх мэдээллийн агуулга, арга замыг тодорхойлох;
- Олон улсын түвшинд сүрьеэгийн өвчлөлтэй холбоотой тайлагналтыг сайжруулах.

Сүрьеэгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээ нь үндэсний түвшинд Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр, холбогдох бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, зарцуулагдаж буй нөөц, хүрсэн үр дүнг тооцох багц шалгуур үзүүлэлт, тэдгээрийн зорилтоос бүрдэнэ.

## 1.2. Сүрьеэ өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд нь Сүрьеэ өвчнөөс сэргийлэх, эмчилгээ, тусламж, үйлчилгээний хүртээмж, үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй арга хэмжээ болон Сүрьеэгийн асуудлаарх үүрэг амлалтын хэрэгжилт болон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдал, хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг тодорхойлох, тохируулга хийх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэглэгдэнэ. Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг Тогтвортой хөгжлийн зорилт, төрийн бодлого, үндэсний хөтөлбөр болон Глобаль сангийн ДОХ, сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэх төсөл, олон улсын тайлангийн шалгуур үзүүлэлтүүдийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно.

Шалгуур үзүүлэлтийг үр нөлөөний, үр дүнгийн, орцын, гарцын гэсэн ангиллаар үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний удирдлага, зохицуулалт гэсэн бүлэг тус бүрээр тооцохоор тусгагдсан болно

Сүрьеэ өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийн суурь үзүүлэлт, дэвшүүлсэн зорилтууд, мэдээллийн эх сурвалжийг Хүснэгт 1-т шалгуур үзүүлэлт тус бүрийн дэлгэрэнгүйг нэгтгэн харуулав.

Хүснэгт 1

## Сүрьеэ өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь үзүүлэлт 2019 | Хүрэх үр дүн /он/ | | Эх сурвалж |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2020 | 2021 | |
| А. Үр нөлөөний шалгуур үзүүлэлт | | | | | | |
| 1 | Сүрьеэгийн шинэ өвчлөлийн түвшин (100.000 хүн амд) | Децимиль | 428 | 428 | 428 | Эрүүл мэндийн үзүүлэлт статистикийн тайлан мэдээ |
| 2 | Сүрьеэгийн нас баралтын түвшин (100.000 хүн амд) | Децимиль | 8.4 | 8.3 | 8.0 | Эрүүл мэндийн үзүүлэлт статистикийн тайлан мэдээ |
| Б. Үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд | | | | | | |
| 1 | Бүх хэлбэрийн сүрьеэгийн илрүүлэлтийн хувь (шинэ, дахилт) | Хувь | 30.0 | 40.0 | 45.0 | ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тайлан |
| 2 | Бүх хэлбэрийн сүрьеэгийн (нян судлалын шинжилгээгээр батлагдсан болон эмнэлзүйн шинж тэмдгээр оношлогдсон) эмчилгээний амжилтын хувь | Хувь | 90.6 | 91.0 | 91.0 | ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тайлан |
| 3 | Рифампицинд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдлын эмчилгээний амжилтын хувь | Хувь | 56.4 | 58.0 | 60.0 | ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тайлан |
| 4 | Нян судлалын шинжилгээгээр батлагдсан сүрьеэгийн тохиолдлын эмчилгээний хяналт алдагдсан хувь | Хувь | 5.5 | 5.0 | 4.0 | ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тайлан |
| 5 | Рифампицинд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээнд хамрагдалтын хувь | Хувь | 85.7 | 88.0 | 90.0 | ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тайлан |

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь үзүүлэлт 2019 | Хүрэх үр дүн /он/ | | Эх сурвалж |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2020 | 2021 | |
| 6 | Зорилт буюу эрсдэлт бүлгийн хүн амаас илэрсэн сүрьеэгийн тохиолдлын тоо | Бодит тоо | Т* | Жил бүр 10%-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ | | ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тайлан |
| В. Орцын шалгуур үзүүлэлт | | | | | | |
| 1 | Сүрьеэгийн оношилгоонд молекул биологийн шинжилгээ ашиглаж буй лабораторийн тоо | Бодит тоо | 19 | 29 | 41 | ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тайлан |
| 2 | Зөөврийн рентген аппаратаар хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо | Бодит тоо | 15 | 29 | 30 | ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тайлан |
| 3 | Сүрьеэгийн 2 дугаар эгнээний эмийн төлбөрт улсын төсвийн санхүүжилтийн эзлэх хувь | Хувь | 20 | 20 | 30 | ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тайлан |
| 4 | Олон нийтэд суурилсан хяналттай эмчилгээгээр эмчлэгдсэн сүрьеэтэй өвчтөний эзлэх хувь | Хувь | 11 | 15 | 20 | ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тайлан |
| Г. Гарцын шалгуур үзүүлэлт | | | | | | |
| 1 | Богино хугацааны эмчилгээнд хамрагдсан олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн өвчтөний эзлэх хувь | Хувь | 50 | 50 | 55 | ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тайлан |
| 2 | Үйлчилгээ үзүүлэгчийн санаачлагаар хийгдэх ХДХВ илрүүлэх шинжилгээнд хамрагдсан сүрьеэтэй өвчтөний хувь (≥15 нас) | Хувь | 86 | 87 | 90 | ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тайлан |
| 3 | Цахим мэдээллийн систем (TUBIS)-г ашиглаж байгаа сүрьеэгийн тасаг, нэгж | Бодит тоо | 30 | 31 | 33 | ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албаны тайлан |
| 4 | Сүрьеэгийн эмчийн үндсэн мэргэшил эзэмшүүлэх сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо | Бодит тоо | 15 | 25 | 35 | Эрүүл мэндийн үзүүлэлт статистикийн тайлан мэдээ |

Т*-2020 онд тодорхойлно

## 1.2. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТООЦОХ АРГА

Хүснэгт 2

### А1. СҮРЬЕЭГИЙН ШИНЭ ӨВЧЛӨЛИЙН ТҮВШИН (100 000 ХҮН АМД)

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Үр нөлөөний шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Тайлант хугацааны турш 100 000 хүн амд шинээр болон дахилт байдлаар өвчилсөн сүрьеэгийн тохиолдлын тоо |
| Нэр томьёоны тодорхойлолт | Шинэ: Өмнө нь сүрьеэгийн эмчилгээнд хамрагдаж байгаагүй эсвэл сүрьеэгийн эмийг нэг сар хүртэлх хугацаанд хэрэглэж байсан сүрьеэгийн тохиолдол;<br>Дахилт: Өмнөх эмчилгээний үр дүнг “эдгэрсэн” эсвэл “эмчилгээ дуусгасан” гэж тооцсон боловч дахин сүрьеэгээр өвчилсөн тохиолдол. |
| Тооцох арга | Энэхүү тооцооллыг ДЭМБ-аас сүрьеэгийн тархалт, дарамт, илрүүлэлтийн түвшин зэрэгт үндэслэн тооцоолж, жил бүрийн “Дэлхийн сүрьеэгийн тайлан”-гаар мэдээлдэг. |
| Хэмжих нэгж | Децимиль |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2019 он - 428<br>- Зорилтот түвшин, 2021 он - 428 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40- 44, 45-аас дээш |
| Хэрэглээ | - Сүрьеэгийн өвчинтэй тэмцэх, сэргийлэх хөтөлбөр, төслийн ажлын үр нөлөөг үнэлэх;<br>- Сүрьеэгийн илрүүлэлтийн түвшинг тодорхойлох<br>- Хөрөнгө оруулалтын хуваарилалтад ашиглах |
| Мэдээллийн эх үүсвэр | - ДЭМБ-ын тайлан,<br>- Өвчний дарамтын тооцоолол |
| Давтамж | Жил бүр |

## A2. СҮРЬЕЭГИЙН НАС БАРАЛТЫН ТҮВШИН (100 000 ХҮН АМД)

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Үр нөлөөний шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Сүрьеэгийн улмаас нас барсан тохиолдлын тоог 100000 хүн амд харьцуулсан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Сүрьеэгийн шалтгаант нас баралт: Нас баралтын шалтгаан нь сүрьеэ өвчин байх<br>- Жилийн дундаж хүн амын тоо: тайлант оны эхний болон эцсийн хүн амын тооны дунджаар илэрхийлэгдэнэ. |
| Тооцох арга | $\frac{\text{Сүрьеэгийн шалтгаант нас баралтын тоо}}{\text{Жилийн дундаж хүн амын тоо}} * 10000$ |
| Хэмжих нэгж | Децимиль |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2018 он – 8.4<br>- Зорилтот түвшин, 2021 он – 8.0 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40- 44, 45-аас дээш |
| Хэрэглээ | - Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх хөтөлбөр, төслүүдийн ажлын үр нөлөөг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | - Сүрьеэгийн улмаас нас барсан тохиолдлын тоо:<br>Жилийн эцсийн эрүүл мэндийн статистик мэдээ, ЭМЯ, ЭМХТ<br>- Жилийн дундаж хүн амын тоо: Жилийн эцсийн иргэний бүртгэлийн мэдээ, ҮСХ |
| Давтамж | Жил бүр |

## Б1. БҮХ ХЭЛБЭРИЙН СҮРЬЕЭГИЙН ИЛРҮҮЛЭЛТИЙН ХУВЬ (ШИНЭ БОЛОН ДАХИЛТ)

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Тухай жилд шинээр болон дахилтаар бүртгэгдсэн сүрьеэгийн тохиолдлын тоог тооцоолсон шинэ өвчлөлийн бодит тоонд харьцуулсан хувь |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Шинэ: Өмнө нь сүрьеэгийн эмчилгээнд хамрагдаж байгаагүй эсвэл сүрьеэгийн эмийг нэг сар хүртэлх хугацаанд хэрэглэж байсан сүрьеэгийн тохиолдол;<br>- Дахилт: Өмнөх эмчилгээний үр дүнг "эдгэрсэн" эсвэл "эмчилгээ дуусгасан" гэж тооцсон боловч дахин сүрьеэгээр өвчилсөн тохиолдол.<br>- Тооцоолсон шинэ өвчлөлийн тоо: "Монгол Улсын хүн амын дундах сүрьеэгийн тархалтыг тогтоох судалгаа 2014-2015"-ны үр дүнд үндэслэн шинэ өвчлөлийн түвшин 100,000 хүн амд 428 гэж тооцоолсон. |
| Тооцох арга | $\frac{\text{Бүртгэгдсэн тохиолдлын тоо (шинэ + дахилт)}}{\text{Тооцоолсон шинэ өвчлөлийн тоо}} * 100\%$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2019 он – 30%<br>- Зорилтот түвшин, 2021 он – 45% |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: Хот, хөдөө<br>- Насны бүлэг: 15-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40- 44, 45-аас дээш |
| Хэрэглээ | - Сүрьеэгийн илрүүлэлтийг үнэлэх;<br>- Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх хөтөлбөр, төслүүдийн ажлын үр дүнг үнэлэх; |
| Мэдээллийн эх үүсвэр | - ХӨСҮТ, СТСА тайлан<br>- ДЭМБ-ын сүрьеэгийн тайлан |
| Давтамж | Улирал, жил бүр |

## Б2. БҮХ ХЭЛБЭРИЙН СҮРЬЕЭГИЙН (НЯН СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭГЭЭР БАТЛАГДСАН БОЛОН ЭМНЭЛЗҮЙН ШИНЖ ТЭМДГЭЭР ОНОШЛОГДСОН) ЭМЧИЛГЭЭНИЙ АМЖИЛТЫН ХУВЬ

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Бүх хэлбэрийн сүрьеэгийн (нян судлалын шинжилгээгээр батлагдсан болон эмнэлзүйн шинж тэмдгээр оношлогдсон) эдгэрсэн болон эмчилгээ дуусгасан тохиолдлын эзлэх хувь |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Нян судлалын шинжилгээгээр батлагдсан сүрьеэгийн тохиолдол: Биологийн сорьцонд хийсэн түрхэц, өсгөвөрлөх ба/эсвэл молекул биологийн шинжилгээ (Xpert MTB/RIF гэх мэт)-ээр батлагдсан тохиолдол<br>- Эдгэрсэн: Нян судлалын шинжилгээгээр батлагдсан уушгины сүрьеэтэй өвчтөний эмчилгээний хяналтын сүүлийн ба түүний өмнөх аль нэг сард түрхэц/өсгөвөрлөх шинжилгээний хариу “сөрөг” байх.<br>- Эмчилгээ дуусгасан: Сүрьеэгийн эмчилгээг бүрэн хийлгэсэн, үр дүнгүй болох нь нотлогдоогүй, эмчилгээ хяналтын шинжилгээ “сөрөг” байсан болович сүүлийн сарын түрхэц/өсгөвөрлөх шинжилгээ хийгдээгүй. |
| Тооцох арга | $\frac{\text{Эдгэрсэн болон эмчилгээ дуусгасан тохиолдлын тоо}}{\text{Эмчилгээний үр дүнг тооцсон тохиолдлын тоо}} * 100\%$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2019 он – 90.6%<br>- Зорилтот түвшин, 2021 он – 91% |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: хот, хөдөө<br>- Байгууллагаар |
| Хэрэглээ | - Сүрьеэгийн эмчилгээний үр дүнг үнэлэх;<br>- Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх хөтөлбөр, төслүүдийн ажлын үр дүнг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | Эмчилгээний үр дүнгийн тайлан, ХӨСҮТ |
| Давтамж | Улирал, жил бүр |

## Б3. ОЛОН ЭМЭНД БОЛОН РИФАМПИЦИНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭГИЙН ТОХИОЛДЛЫН ЭМЧИЛГЭЭНИЙ АМЖИЛТЫН ХУВЬ

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Олон эмэнд болон рифампицинд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдлын доторх эдгэрсэн болон эмчилгээ дуусгасан тохиолдлын эзлэх хувь |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Олон эмэнд тэсвэртэй сүрьеэ (ОЭТС): Изониазид ба рифампицинд хоёуланд тэсвэртэй эсвэл изониазид, рифампицинд тэсвэртэйн дээр бусад нэгдүгээр эгнээний эмэнд тэсвэртэй;<br>- Рифампицинд тэсвэртэй сүрьеэ (Риф): Рифампицинд тэсвэртэй нь шинжилгээгээр батлагдсан (Үүнд: нэг эмэнд тэсвэртэй-зөвхөн рифампицинд тэсвэртэй, цөөн эмэнд тэсвэртэй сүрьеэ-рифампицин орсон тэсвэртэй хэлбэр, олон эмэнд тэсвэртэй сүрьеэ, маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэ)<br>- Эдгэрсэн: Эмчилгээг бүрэн гүйцэд хийлгэсэн, эмчилгээ үр дүнгүй болсон гэх нотолгоогүй ба үргэлжлэх шатны эмчилгээний сүүлийн саруудад хамгийн багадаа 30 хоногийн зайтай дараалан хийсэн 3 ба түүнээс дээш өсгөврийн шинжилгээ сөрөг тохиолдол;<br>- Эмчилгээ дуусгасан: Эмчилгээг бүрэн гүйцэд хийлгэсэн, эмчилгээ үр дүнгүй болсон гэх нотолгоогүй ба үргэлжлэх шатны эмчилгээний сүүлийн саруудад хамгийн багадаа 30 хоногийн зайтай дараалан хийсэн 3 ба түүнээс дээш өсгөврийн шинжилгээ сөрөг болсон нь бүртгэгдээгүй тохиолдол; |
| Тооцох арга | $\frac{\text{Эдгэрсэн + эмчилгээ дуусгасан тохиолдлын тоо}}{\text{Үр дүн тооцсон тохиолдлын тоо}} * 100\%$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2019 он – 56.4%<br>- Зорилтот түвшин, 2021 он – 60% |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: хот, хөдөө<br>- Байгууллагаар |
| Хэрэглээ | - Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээний үр дүнг үнэлэх;<br>- Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх хөтөлбөр, төслүүдийн ажлын үр дүнг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | - Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээний үр дүнгийн тайлан, ХӨСҮТ |
| Давтамж | Улирал, жил бүр |

## Б4. НЯН СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭГЭЭР БАТЛАГДСАН СҮРЬЕЭГИЙН ТОХИОЛДЛЫН ЭМЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ АЛДАГДСАН ХУВЬ

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Нян судлалын шинжилгээгээр батлагдсан сүрьеэгийн шинэ тохиолдлын доторх хяналт алдагдсан тохиолдлын эзлэх хувь |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Нян судлалын шинжилгээгээр батлагдсан сүрьеэгийн тохиолдол: Биологийн сорьцонд хийсэн түрхэц, өсгөвөрлөх ба/эсвэл молекул биологийн шинжилгээ (Xpert MTB/RIF гэх мэт)-ээр батлагдсан тохиолдол<br>- Хяналт алдагдсан тохиолдол: Сүрьеэ өвчин оношлогдсон боловч эмчилгээнд хамрагдаагүй эсвэл эмчилгээг дараалан 2 ба түүнээс дээш сараар тасалсан тохиолдол. |
| Тооцох арга | $\frac{\text{Хяналт алдагдсан тохиолдлын тоо}}{\text{Үр дүн тооцсон тохиолдлын тоо}} * 100\%$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2019 он – 5.5%<br>- Зорилтот түвшин, 2021 он – 4.0% |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: хот, хөдөө<br>- Байгууллагаар |
| Хэрэглээ | - Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээний үр дүнг үнэлэх;<br>- Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх хөтөлбөр, төслүүдийн ажлын үр дүнг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээний үр дүнгийн тайлан, ХӨСҮТ |
| Давтамж | Улирал, жил бүр |

## Б5. РИФАМПИЦИНД ТЭСВЭРТЭЙ ОНОШЛОГДСОН СҮРЬЕЭГИЙН ЭМЧИЛГЭЭНД ХАМРАГДАЛТЫН ХУВЬ

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Оношлогдсон рифампицинд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдлоос сүрьеэгийн 2 дугаар эгнээний эмчилгээнд хамрагдсан хувь |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Олон эмэнд тэсвэртэй сүрьеэ (ОЭТС): Изониазид ба рифампицинд хоёуланд тэсвэртэй эсвэл изониазид, рифампицинд тэсвэртэйн дээр бусад нэгдүгээр эгнээний эмэнд тэсвэртэй;<br>- Рифампицинд тэсвэртэй сүрьеэ (Риф): Рифампицинд тэсвэртэй нь шинжилгээгээр батлагдсан (Үүнд: нэг эмэнд тэсвэртэй-зөвхөн рифампицинд тэсвэртэй, цөөн эмэнд тэсвэртэй сүрьеэ-рифампицин орсон тэсвэртэй хэлбэр, олон эмэнд тэсвэртэй сүрьеэ, маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэ)<br>- Сүрьеэгийн 2 дугаар эгнээний эмчилгээнд хамрагдсан тохиолдлын тоо: тухайн оношлогдсон жилдээ эмчилгээнд хамрагдсан тохиолдол |
| Тооцох арга | $\frac{\text{Эмчилгээнд хамрагдсан тохиолдлын тоо}}{\text{Рифампицинд тэсвэртэй оношлогдсон тохиолдлын тоо}} * 100\%$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2019 он – 85.7%<br>- Зорилтот түвшин, 2021 он – 90% |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: хот, хөдөө<br>- Байгууллагаар |
| Хэрэглээ | - Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг үнэлэх;<br>- Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх хөтөлбөр, төслүүдийн ажлын үр дүнг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | - Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тайлан, ХӨСҮТ |
| Давтамж | Жил бүр |

**Б6. ЗОРИЛТОТ БУЮУ ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМААС ИЛЭРСЭН СҮРЬЕЭГИЙН ТОХИОЛДЛЫН ТОО**

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Орцын шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Сүрьеэгийн идэвхтэй илрүүлгээр эрсдэлт бүлгийн хүн амын дунд тухайн жилд сүрьеэгийн тохиолдлыг баталгаажуулсан бодит тоо |
| Нэр томьёоны тодорхойлолт | Эрсдэлт бүлгийн хүн амд гэж сүрьеэтэй өвчтөний ойрын хавьтал, хот, суурин газрын эмзэг бүлгийн иргэд, хорих ангид хүмүүжигчид, орон гэргүй иргэд, чихрийн шижинтэй өвчтөн, хувиараа ашигт малтмал олборлогчдыг хэлнэ. |
| Тооцох арга | Тухайн жилд эрсдэлт бүлгийн хүн амын дунд сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг үзлэгээр шинээр илэрсэн сүрьеэгийн тоо |
| Хэмжих нэгж | Бодит тоо |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2019 он – 2020 онд тодорхойлогдоно<br>- Зорилтот түвшин, 2021 он – 10%-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: хот, хөдөө |
| Хэрэглээ | - Сүрьеэ өвчний тандалт, эрдэм шинжилгээнд ашиглах<br>- Эрсдэлт бүлгийн хүн амын эрүүл мэндийн байдал<br>- Үндэсний түвшинд сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлт зохион байгуулах чадавхийг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | - Жилийн эцсийн тайлан мэдээ, ХӨСҮТ-ийн СТСА<br>- Төрийн бус байгууллагын тайлан |
| Давтамж | Жил бүр |

Хүснэгт 10

### B1. СҮРЬЕЭГИЙН ОНОШИЛГООНД МОЛЕКУЛ БИОЛОГИЙН ШИНЖИЛГЭЭ АШИГЛАЖ БУЙ ЛАБОРАТОРИЙН ТОО

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Орцын шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Сүрьеэг оношилох хурдавчилсан оношилгооны аппарат (Gene-Xpert) ашиглаж буй лабораторийн тоо |
| Нэр томьёоны тодорхойлолт | Молекул биологийн шинжилгээ – XpertMTB/RIF эсвэл XpertMTB/RIFUltra зэрэг молекул биологийн аргад үндэслэн үүсгэгчийг илрүүлж, эмэнд тэсвэржилтийг тодорхойлдог шинжилгээ |
| Тооцох арга | Сүрьеэгийн үндэсний лавлах лабораторийн үйл ажиллагааны тайлан |
| Хэмжих нэгж | Бодит тоо |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2019 он – 19<br>- Зорилтот түвшин, 2021 он – 41 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: хот, хөдөө |
| Хэрэглээ | Үндэсний түвшинд оношилгооны чадавхийг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | Сүрьеэгийн үндэсний лавлагаа лабораторийн үйл ажиллагааны тайлан |
| Давтамж | Жил бүр |

Хүснэгт 11

## В2. ЗӨӨВРИЙН РЕНТГЕН АППАРАТААР ХАНГАГДСАН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОО

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Орцын шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Зөөврийн рентген аппаратаар хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо (21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг, хорих 429 дүгээр ангийн эмнэлэг, нийт 31 байгууллага) |
| Нэр томьёоны тодорхойлолт | Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг хийхэд зөөвөрлөн ашиглах боломжтой, дижитал технологид суурилсан рентген аппарат |
| Тооцох арга | Зөөврийн рентген аппаратаар хангагдсан 21 аймгийн нэгдсэн эмнэлэг болон нийслэлийн 9 дүүргийн Эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, хорих 429 дүгээр ангийн эмнэлэг зэрэг байгууллагын тоо |
| Хэмжих нэгж | Бодит тоо |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин 2019 он – 15<br>- Зорилтот түвшин 2021 он – 30 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: хот, хөдөө |
| Хэрэглээ | - Үндэсний түвшинд сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг зохион байгуулах чадавхийг үнэлэх;<br>- Ханган нийлүүлсэн тоног төхөөрөмжийн ашиглалтыг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | - Аймаг, дүүргийн “Халдварт өвчнийг хянах, сэргийлэх үндэсний хөтөлбөр”-ийн биелэлтийн тайлан;<br>- ХӨСҮТ-ийн СТСА-ны жилийн эцсийн тайлан |
| Давтамж | Жил бүр |

## B3. СҮРЬЕЭГИЙН 2 ДУГААР ЭГНЭЭНИЙ ЭМИЙН ТӨЛБӨРТ УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Орцын шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Сүрьеэгийн 2 дугаар эгнээний эм худалдан авахад улсын төсвөөс зарцуулсан санхүүжилтийн эзлэх хувь |
| Нэр томьёоны тодорхойлолт | Сүрьеэгийн 2 дугаар эгнээний эм: эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөнийг эмчлэх эмүүд |
| Тооцох арга | $\frac{\text{Улсын төсвөөс зарцуулсан санхжүүжилт}}{\text{2 дугаар эгнээний эм худалдан авсан нийт санхүүжилт}} * 100\%$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин 2019 он – 20%<br>- Зорилтот түвшин 2021 он – 30% |
| Задаргаа | Улсын хэмжээнд |
| Хэрэглээ | - Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагаанд Засгийн газрын оролцоог үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | - Жилийн батлагдсан төсөв, ЭМЯ<br>- Төсвийн гүйцэтгэл, ХӨСҮТ, ЭМЯ<br>- ХӨСҮТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийн үнэлгээний хорооны тайлан, гэрээ |
| Давтамж | Жил бүр |

## B4. ОЛОН НИЙТЭД СУУРИЛСАН ЭМЧИЛГЭЭГЭЭР ЭМЧЛЭГДСЭН СҮРЬЕЭТЭЙ ӨВЧТӨНИЙ ХУВЬ

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Орцын шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Нийт эмчилгээнд хамрагдсан тохиолдлын дунд (эмэнд тэсвэртэй сүрьеэг оролцуулна) эмчилгээний явцад олон нийтэд суурилсан буюу сайн дурын ажилтан, өрхийн гишүүний хяналтад эмчлэгдсэн өвчтөний эзлэх хувь |
| Нэр томьёоны тодорхойлолт | Олон нийтэд суурилсан эмчилгээ: сүрьеэгийн эмчилгээг сургагдсан сайн дурын ажилтан болон өрхийн гишүүний хяналттайгаар үргэлжүүлэхийг хэлнэ. |
| Тооцох арга | $$\frac{\text{Олон нийтэд суурилсан эмчилгээнд хамрагдсан өвчтөн}}{\text{Эмчилгээ хамрагдсан бүх өвчтөн}} * 100\%$$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин 2019 он – 15%<br>- Зорилтот түвшин 2021 он – 20% |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: хот, хөдөө<br>- Өвчлөл өндөр, дунд 14 аймаг, төвийн 6 дүүрэг<br>- Бусад байгууллага: Энэрэл эмнэлэг |
| Хэрэглээ | Үндэсний болон орон нутгийн түвшинд сүрьеэгийн тусламж, үйлчилгээнд олон нийтийн оролцоог үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | - Жилийн эцсийн тайлан мэдээ, ХӨСҮТ-ийн СТСА,<br>- Монголын Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн тайлан |
| Давтамж | Жил бүр |

Хүснэгт 14

## Г1. БОГИНО ХУГАЦААНЫ ЭМЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ОЛОН ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭТЭЙ ӨВЧТӨНИЙ ЭЗЛЭХ ХУВЬ

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Гарцын шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Олон эмэнд буюу рифампицинд тэсвэртэй тохиолдлын дундах ДЭМБ-аас зөвлөсөн богино хугацааны горим (9-12 сар)-ийн эмчилгээнд хамрагдсан өвчтөний эзлэх хувь |
| Нэр томьёоны тодорхойлолт | - Олон эмэнд тэсвэртэй сүрьеэ (ОЭТС): Изониазид ба рифампицинд хоёуланд тэсвэртэй эсвэл изониазид, рифампицинд тэсвэртэй дээр бусад нэгдүгээр эгнээний эмэнд тэсвэртэй;<br>- Рифампицинд тэсвэртэй сүрьеэ (Риф): Рифампицинд тэсвэртэй нь шинжилгээгээр батлагдсан (Үүнд: нэг эмэнд тэсвэртэй-зөвхөн рифампицинд тэсвэртэй, цөөн эмэнд тэсвэртэй сүрьеэ-рифампицин орсон тэсвэртэй хэлбэр, олон эмэнд тэсвэртэй сүрьеэ, маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэ);<br>- ОЭТС-ийн богино хугацааны эмчилгээний горим: Риф/ОЭТС-ийн эмчилгээнд тогтсон стандарт горимыг 9-12 сарын хугацаанд хэрэглэх. |
| Тооцох арга | $\frac{\text{Богино хугацааны горимоор эмчилгээтэй өвчтөн}}{\text{Эмчилгээнд хамрагдсан Риф, ОЭТС} - \text{тэй бүх өвчтөн}} * 100\%$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин 2019 он – 50%<br>- Зорилтот түвшин 2021 он – 55% |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байршил: хот, хөдөө |
| Хэрэглээ | - Үндэсний түвшинд хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилт,<br>- Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн менежментийг дүгнэх, үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | Жилийн эцсийн тайлан мэдээ, ХӨСҮТ-ийн СТСА, |
| Давтамж | Жил бүр |

## Г2. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН САНААЧЛАГААР ХИЙГДЭХ ХДХВ ИЛРҮҮЛЭХ ШИНЖИЛГЭЭНД ХАМРАГДСАН СҮРЬЕЭТЭЙ ӨВЧТӨНИЙ ХУВЬ (≥15 НАС)

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Гарцын шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Шинээр болон дахилтаар бүртгэгдсэн сүрьеэтэй 15-аас дээш насны өвчтнүүдээс ХДХВ-ийн халдвар бүртгэгдсэн өвчтөний эзлэх хувь |
| Нэр томьёоны тодорхойлолт | Үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар хийгдэх ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний хариу бүртгэгдсэн байдал |
| Тооцох арга | $\frac{\text{ХДХВ} - \text{ийн статус бүртгэгдсэн тохиолдлын тоо}}{\text{Шинээр болон дахилтаар бүртгэгдсэн тохиолдлын тоо}} * 100$ |
| Хэмжих нэгж | Хувь |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин, 2019 он – 86%<br>- Зорилтот түвшин, 2021 он - 90% |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байгууллагаар |
| Хэрэглээ | - Сүрьеэ болон ДОХ, БЗДХ-тай тэмцэх сэргийлэх хөтөлбөрийн хамтын ажиллагааг үнэлэх |
| Мэдээллийн эх үүсвэр | Жилийн эцсийн тайлан, ХӨСҮТ, СТСА |
| Давтамж | Жил бүр |

## Г3. ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ (TUBIS)-Г АШИГЛАЖ БАЙГАА СҮРЬЕЭГИЙН ТАСАГ, НЭГЖ

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Гарцын шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | ЭМЯ-аас зөвшөөрөгдсөн цахим мэдээллийн шинэчилсэн систем (TUBIS)-ийг ашиглаж байгаа сүрьеэгийн тасаг, нэгжийн тоо |
| Нэр томьёоны тодорхойлолт | ЭМЯ-аас зөвшөөрөгдсөн цахим мэдээллийн шинэчилсэн систем (TUBIS)-ийг ашиглаж байгаа: TUBIS программыг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж, тайлан мэдээг гаргаж хэвшсэн байдал |
| Тооцох арга | TUBIS программыг ашиглан СҮ-7, СҮ-8, Эмийн тайланг бүрэн гүйцэт, чанартай гарган авч илгээж буй нэгжийн тоогоор илэрхийлэгдэнэ. |
| Хэмжих нэгж | Бодит тоо |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин 2019 он – 10<br>- Зорилтот түвшин 2021 он – 33 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байгууллагаар |
| Хэрэглээ | - Үндэсний хэмжээнд хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг дүгнэх, үнэлэх, цахим сүлжээний баяжилт<br>- Сүрьеэгийн тохиолдолд суурилсан өгөгдлийн сангийн чанар, үнэн, зөв байдлыг дүгнэх |
| Мэдээллийн эх үүсвэр | - Улирлын эргэн мэдээлэл, ХӨСҮТ, СТСА<br>- Жилийн эцсийн тайлан, ХӨСҮТ, СТСА |
| Давтамж | Улирал, жил бүр |

Хүснэгт 17

**Г4. СҮРЬЕЭГИЙН ЭМЧИЙН ҮНДСЭН МЭРГЭШИЛ ЭЗЭМШҮҮЛЭХ СУРГАЛТАД ХАМРАГДСАН ЭМЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ТОО**

| | |
|---|---|
| Үзүүлэлтийн төрөл | Гарцын шалгуур үзүүлэлт |
| Үзүүлэлтийн тодорхойлолт | Тухайн жилд сүрьеэгийн мэргэжлийн эмчийг шинээр бэлтгэсэн аймаг, дүүргийг хувиар гаргасан үзүүлэлт |
| Нэр томьёоны тодорхойлолт | Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хүний их эмч төгсөлтийн дараах сүрьеэгийн сургалтын хөтөлбөрийн дагуу суралцаж, сүрьеэгийн эмчийн мэргэжил эзэмшүүлэх сургалт |
| Тооцох арга | Тухайн хичээлийн жилд сүрьеэгийн эмчийн мэргэжил эзэмшүүлэх сургалт хамрагдаж, төгссөн их эмчийн тоогоор тооцно |
| Хэмжих нэгж | Бодит тоо |
| Зорилтот түвшин | - Суурь түвшин 2019 он – 15<br>- Зорилтот түвшин 2021 он - 35 |
| Задаргаа | - Засаг, захиргааны нэгж: Улс, аймаг, нийслэл<br>- Байгууллагаар |
| Хэрэглээ | - Сүрьеэгийн тусламж, үйлчилгээний чанарыг үнэлэх;<br>- Хүний нөөцийн хангамжийг дүгнэх |
| Мэдээллийн эх үүсвэр | Эрүүл мэндийн хөгжлийн тайлан<br>Аймаг, нийслэлийн сүрьеэгийн 32 нэгжийн тайлан |
| Давтамж | Жил бүр |

## 1.3. Мэдээлэл цуглуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэсний тогтолцооны урсгал

Энэ бүлэгт Сүрьеэ өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны зохицуулалт, шалгуур үзүүлэлтийг тооцоход шаардлагатай өгөгдөл, мэдээллийг бүртгэх, цуглуулах, дамжуулах, боловсруулах үйл явц, мэдээллийн урсгал, мэдээллийн эх сурвалж зэрэг тусгагдсан.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээний мэдээллийг эрүүл мэндийн салбарын статистик мэдээлэл, Сүрьеэ өвчнөөс сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээнд оролцогч төр, төрийн бус, хувийн хэвшлийн болон олон улсын байгууллагуудын холбогдох мэдээллийг цуглуулж, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, бодлого боловсруулахад ашиглана.

Хяналт-шинжилгээ үнэлгээний хүрээнд эрүүл мэндийн үйлчилгээнд суурилсан мэдээллийн эх сурвалжийг ашиглана:

- Эрүүл мэндийн бүртгэл мэдээлэл (эрүүл мэндийн статистик мэдээлэл);
- Эрүүл мэндийн үйлчилгээний талаарх мэдээлэл (хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан);
- Байгууллагад түшиглэсэн судалгаа (судалгаагаар гарах мэдээлэл).

Холбогдох бүртгэл, тайлангаас гадна интернет-д суурилсан сүрьеэгийн цахим бүртгэлийн (TUBIS) тогтолцоо хэрэгжиж байна. Мөн интернетэд суурилсан цахим бүртгэлийн тогтолцоонд (H-Info) зөвхөн шинээр илэрсэн сүрьеэгийн тохиолдлыг бүртгэдэг.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэсний тогтолцооны урсгалыг Зураг 1, Сүрьеэгийн бүртгэл, мэдээллийн урсгалыг Зураг 2-т тус тус харуулав.

Зураг 1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэсний тогтолцооны урсгал



Зураг 2. Сүрьеэ өвчний бүртгэл, мэдээллийн урсгал



## 1.4. Мэдээллийн эх сурвалж

Сүрьеэ өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны 16 шалгуур үзүүлэлтийг тооцох болон хяналт-шинжилгээ, үнэлгээнд ашиглах мэдээллийн эх сурвалжийг Хүснэгт 18-д харуулсан.

Хүснэгт 18. Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн эх сурвалж

| Дугаар | Маягтын нэр | Төрөл | Хэрэглэх заавар | Хэрэглэгч |
|---|---|---|---|---|
| СҮ-1 | Сүрьеэгийн тохиолдлын бүртгэл | Бүртгэл | Сүрьеэтэй гэж оношлогдсон тохиолдол бүрийг "Сүрьеэгийн тохиолдлын бүртгэл"-д бүртгэж авна.<br>Сүрьеэгийн оношилгоо, бүртгэл, эмчилгээ, хяналтыг хийж буй сүрьеэгийн нэгж бүртгэлийг хөтөлнө. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| СҮ-2 | Сүрьеэтэй өвчтөний эмчилгээ, хяналтын карт | Бүртгэл | Бүртгэгдэж эмчилгээ эхэлсэн сүрьеэгийн тохиолдол бүрд СҮ-2 маягтыг хөтөлнө.<br>Хяналтаас хасагдсаны дараа ХӨСҮТ-ийн СТСА-ны төвлөрсөн бүртгэлд илгээнэ. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| СҮ-3 | Хүчилд тэсвэртэй нян илрүүлэх шинжилгээний хуудас | Бүртгэл | Сүрьеэгийн сэжигтэй тохиолдлын сорьцыг түрхэц, Xpert MTB/RIF шинжилгээнд илгээх болон шинжилгээний хариу бичих хуудас. | Сүрьеэгийн онош тодруулахаар илгээж буй эмч, лаборант |
| СҮ-4 | Биологийн сорьцонд сүрьеэгийн үүсгэгч илрүүлэх шинжилгээний хуудас | Бүртгэл | Түрхэц, өсгөвөрлөх, Xpert MTB/RIF, молекул биологийн шинжилгээ, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээний хуудас.<br>ХӨСҮТ-ийн СТСА-ны Сүрьеэгийн үндэсний лавлагаа лабораторт сорьц илгээхэд уг хуудсыг хөтлөн хамт илгээнэ. | Сүрьеэгийн онош тодруулахаар илгээж буй эмч, лаборант |
| СҮ-5 | Сүрьеэг илрүүлэх шинжилгээний бүртгэл | Бүртгэл | Сүрьеэгийн лабораторид түрхэцийн, Xpert MTB/RIF шинжилгээ хийсэн тухай бүртгэл | Шинжилгээ хийсэн эмч, лаборант |
| СҮ-6 | Сүрьеэгийн лабораторийн шинжилгээний сарын тайлан | Тайлан | Сүрьеэгийн лабораториудын түрхэцийн шинжилгээний гүйцэтгэлийг СҮ-5 бүртгэлээс нэгтгэн сар бүр ХӨСҮТ-ийн СТСА-ны СҮЛЛ-д илгээнэ. | Лаборант |

| | | | | |
|---|---|---|---|---|
| СҮ-7 | Сүрьеэгийн тохиолдлын бүртгэлийн сарын тайлан | Тайлан | Сүрьеэгийн тохиолдлыг оношилж, бүртгэж, эмчилж байгаа аймаг, дүүргийн сүрьеэгийн нэг тайланг сар бүр гаргана. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| СҮ-8 | Сүрьеэгийн эмчилгээний үр дүнгийн тайлан | Тайлан | Сүрьеэгийн нэгж улирал тутам 12-15 сарын өмнө бүртгэгдсэн тохиолдлын эмчилгээний үр дүнг маягтын дагуу бөглөж, ХӨСҮТ-ийн СТСА-нд илгээнэ. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| СҮ-9 | Цэрний түрхэц эерэг өвчтөний эмчилгээний 2, 3 дахь сард түрхэц сөрөгт шилжилтийн тайлан | Тайлан | Сүрьеэгийн нэгжид өмнөх улиралд бүртгэгдсэн түрхэц эерэг өвчтөний эрчимт шатны эмчилгээний үр дүнг улирал тутам илгээнэ | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| СҮ-10 | Сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлын бүртгэл | Бүртгэл | Өрх, сумын эмч, бусад төрөлжсөн мэргэжлийн эмч нар үйлчлүүлэгчийг сүрьеэтэй байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд энэ маягтыг хөтөлж харъяа аймаг, дүүргийн сүрьеэгийн нэгжид сүрьеэг оношлох үзлэг, шинжилгээнд илгээнэ. | Өрх, сумын эмч болон бусад нарийн мэргэжлийн эмч нар |
| СҮ-11 | Сүрьеэтэй өвчтөний хавьтал хяналтын бүртгэл | Бүртгэл | Сүрьеэгийн эмч нар тохиолдол бүр, тэдгээрийн хавьтлыг бүртгэж, үзлэг, шинжилгээнд хамруулж, энэхүү бүртгэлийг хөтөлнө. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| СҮ-12 | Сүрьеэтэй өвчтөний хавьтлын үзлэгийн тайлан | Тайлан | Сүрьеэгийн дүн бүртгэгч, тархвар судлаач эмч нар хамтран улирал тутам тайлан гаргаж ХӨСҮТ-ийн СТСА-нд мэдээлнэ | Тархвар судлаач эмч Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| СҮ-13 | Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн карт | Бүртгэл | Сүрьеэгийн тасагт өвчтөн хэвтэхэд нээх ба эмнэлгээс гарахад нь харьяа аймаг, дүүргийн сүрьеэгийн нэгжид илгээнэ. | Сүрьеэгийн эмч |
| СҮ-14 | Гадаад чанарын үнэлгээний түрхэц дагалдах хуудас | Бүртгэл | Нэгжээс ирсэн түрхэцийг чанарын хяналтын лабораторийн лаборант шалгаж, техник үзүүлэлтийг үнэлж дүгнэнэ. | лаборант |
| СҮ-15 | GeneXpert MTB/RIF шинжилгээний сарын тайлан | Тайлан | Xpert MTB/RIF шинжилгээ хийдэг лабораторт шинжилгээний гүйцэтгэлийг СҮ- | Лаборант |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 5 бүртгэлээс нэгтгэн сар бүр СҮЛЛ-д илгээнэ. Рифампицинд тэсвэртэй илэрсэн тохиолдол бүрийн дэлгэрэнгүй мэдээлэл (өвчтөний овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар, өмнөх эмчилгээний түүх, илэрсэн огноо)-ийг ирүүлнэ. | |
| СҮ-16 | Сүрьеэгийн лабораторийн гадаад чанарын хяналтын эргэх холбооны хуудас | Бүртгэл | Сүрьеэгийн лабораториудын түрхэцийн шинжилгээний чанарын хяналтын үзүүлэлт, шинжилгээг сайжруулах талаар зөвлөмж бичиж, чанарын хяналтад оролцогч лабораторт буцааж илгээх хуудас. | СҮЛЛ-ийн эмч, лаборант |
| СҮ-17 | Өсгөврийн шинжилгээний тайлан | Тайлан | Өсгөвөрлөх шинжилгээ гүйцэтгэдэг сүрьеэгийн лабораторийн өсгөврийн шинжилгээний сар тутмын гүйцэтгэл | Лабораторийн эмч, лаборант |
| СҮ-18 | Лабораторийн урвалж, бодисын зарцуулалтын тайлан | Тайлан | Сүрьеэгийн лабораториуд улирал бүрийн хэрэглэсэн урвалж, бодис болон одоо байгаа нөөцөө гаргаж, шаардлагатай байгаа урвалж, бодисоо захиална. | Лаборант |
| СҮ-19 | Сүрьеэгийн арьсны сорилын улирлын тайлан | Тайлан | Сорилын сувилагч улирал тутам тайлан гаргаж ХӨСҮТ-ийн СТСА-нд мэдээлнэ. | Сум өрх, аймаг дүүргийн сорилын сувилагч Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| СҮ-20 | Изониазидын урьдчилан сэргийлэх эмчилгээний бүртгэл | Бүртгэл | Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд орсон тохиолдол бүрийг энэхүү бүртгэлд бүртгэнэ. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| СҮ-21 | Сүрьеэтэй өвчтөнийг шилжүүлэх маягт | Бүртгэл | Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байх явцад өвчтөн аймаг, дүүргийн хооронд шилжих тохиолдол гарахад энэ маягтыг хөтлөнө. | Сүрьеэгийн эмч |
| СҮ-22 | Сүрьеэгийн хавьтлын үзлэгийн хуудас | Бүртгэл | Сүрьеэгийн эмч, тархвар судлаач эмч нар бүртгэлийг хамтран хөтөлж, хавьтлын үзлэгийн хамралтын байдалд хяналт тавина. | Тархвар судлаач |
| СҮ-23 | Сүрьеэгийн 1 дүгээр эгнээний | Бүртгэл | Сарын дундаж өвчлөлд үндэслэн захиалгыг хийнэ. | Эм хариуцсан сувилагч |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | эмийн захиалгын хуудас | | (Аймаг улиралд 1удаа) СТСА-ны эм хариуцсан хяналтын эмч тухайн аймгийн өвчлөлд үндэслэн эмийн захиалгад хяналт хийж, баталгаажуулж эмийг олгоно | |
| СҮ-24 | Сүрьеэгийн 2 дугаар эгнээний эмийн захиалгын хуудас | Бүртгэл | Эмчилгээтэй байгаа болон эмчилгээнд орж байгаа тохиолдол бүрт 1-3 сараар эмийг тооцоолж захиална. Өвчтөн бүрийн биеийн жин, эмчилгээний горимыг зайлшгүй бичнэ. | Эм хариуцсан сувилагч |
| СҮ-25 | Гаж нөлөөний эмийн захиалгын хуудас | Бүртгэл | ОЭТС-тэй эмчилгээтэй байгаа тохиолдлын тоонд үндэслэн захиалгыг тооцоолно | Эм хариуцсан сувилагч |
| СҮ-26 | Сүрьеэгийн 1 дүгээр эгнээний эмийн тайлан | Тайлан | Сар бүрийн орлого, зарлагыг тооцож, сарын эцсийн үлдэгдлийг гаргана. Эмийн хүчинтэй хугацаа, серийн дугаарыг сайтар шалгана. | Эм хариуцсан сувилагч |
| СҮ-27 | Сүрьеэгийн 2 дугаар эгнээний эмийн тайлан | Тайлан | Сар бүрийн орлого, зарлагыг тооцож, сарын эцсийн үлдэгдлийг гаргана. Эмийн хүчинтэй хугацаа, серийн дугаарыг сайтар шалгана | Эм хариуцсан сувилагч |
| СҮ-28 | Гаж нөлөөний эмийн тайлан | Тайлан | Сар бүрийн орлого, зарлагыг тооцож, сарын эцсийн үлдэгдлийг гаргана. Эмийн хүчинтэй хугацаа, серийн дугаарыг сайтар шалгана. | Эм хариуцсан сувилагч |
| АМ-4 | Сүрьеэгийн тохиолдлыг мэдээлэх хуудас | Бүртгэл | Сүрьеэгийн тохиолдол бүрийг "Сүрьеэгийн тохиолдлыг мэдээлэх хуудас" АМ-4 маягтаар бүртгэн, аймаг, дүүргийн ЭМТ-ийн статистикийн алба болон ХӨСҮТ-ийн СТСА-нд мэдээлнэ | Сүрьеэгийн тохиолдлыг оношилсон эмч |
| ЭТМ-302 | Сүрьеэгийн байгууллагын жилийн үйл ажиллагааны тайлан | Тайлан | Сарын мэдээг өссөн дүнгээр гаргаж жилийн тайланд тусгана. Жилийн үйл ажиллагааны тайланг аймаг, дүүргийн сүрьеэгийн зохицуулагч эмч нар жилийн эцсээр тасалбар болгон гаргаж дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн ЭМГ-ын статистик мэдээллийн алба (СМА)-нд, аймаг, нийслэлийн ЭМГ-ын статистик мэдээллийн алба нь 1 дүгээр сарын 20-ны | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч<br><br>Аймаг дүүргийн ЭМТ-ийн статистик мэдээллийн алба<br><br>Эрүүл мэндийн хөгжлийн төв |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | дотор ХӨСҮТ-ийн СТСА-нд, ХӨСҮТ-ийн СТСА нь 2 дугаар сарын 15-ны дотор ЭМХТ-д хүргүүлнэ. | |
| ЭТС-1А | Рифампицинд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдлын бүртгэлийн маягт | Бүртгэл | Рифампицинд тэсвэртэй сүрьеэгийн бүх тохиолдол (Р, ОЭТС, МОЭТС г.м.)-ыг бүртгэнэ. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| ЭТС-1Б | Нэг болон цөөн эмэнд тэсвэртэй /Рифампици-наас бусад/ сүрьеэгийн бүртгэл | Бүртгэл | Нэг болон цөөн эмэнд тэсвэртэй сүрьеэгийн бүх тохиолдол (Изониазид, Рифампицины хослол болон дан ганц Рифампицинаас бусад)-ыг бүртгэнэ. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| ЭТС-2 | Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний эмчилгээ, хяналтын карт | Бүртгэл | Бүртгэгдсэн эмчилгээ эхэлсэн Рифампицинд тэсвэртэй сүрьеэгийн бүх тохиолдол (Р, ОЭТС, МОЭТС...)-д хөтлөнө. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| ЭТС-3 | Эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээний бүртгэл | Бүртгэл | Түрхэц, өсгөвөрлөх, GeneXpert MTB/RIF, молекул биологийн шинжилгээний үр дүнг тэмдэглэнэ. | Лабораторийн эмч, лаборант |
| ЭТС-4 | Түрхэц, өсгөвөрлөх, GeneXpert MTB/RIF шинжилгээний бүртгэл | Бүртгэл | Сүрьеэгийн эсрэг 1 болон 2 дугаар эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээний үр дүнг бүртгэнэ. | СҮЛЛ-ийн эмч, лаборант |
| ЭТС-5 | Эмийн мэдрэг чанар тодорхойлох шинжилгээний тайлан | Тайлан | ЭМЧТШ-ний гүйцэтгэлийг шинжилгээний төрөл тус бүрээр ЭТС-4, ЭТС-5 бүртгэлээс нэгтгэн гаргана. | СҮЛЛ-ийн эмч, лаборант |
| ЭТС-6 | Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн асуудал шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөний шийдвэр | Бүртгэл | “ЭТС-тэй өвчтөний эмчилгээний асуудал шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөн”-өөр асуудал шийдвэрлүүлсэн өвчтөн бүрт ЭТС-6 маягтын дагуу “Эмч нарын зөвлөгөөний шийдвэр” бичих ба энэ нь өвчтөний эмчилгээ хяналтын карт ЭТС-2А-д хавсрагдана. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч СТСА-ны ЭТС-ийн асуудал хариуцсан мэргэжилтэн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ЭТС-7 | Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлын тайлан | Тайлан | ЭТС-ийн 10 бүртгэлийн маягтыг үндэслэн ЭТС-7 тайланг гаргана. Тухайн нэгжид бүртгэгдсэн ЭТС-тэй байж болзошгүй тохиолдлын тоог тохирох багануудад өмнөх болон тухайн улирлын байдлаар бичнэ. Энэхүү тайлангийн маягтаас ЭТС-ийн сэжигтэй тохиолдлоос ЭМЧТШ-нд хамрагдсан болон ЭТС-тэй батлагдсан тохиолдлын хувийг гаргана. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| ЭТС-7А | Рифампицинд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдлын улирлын тайлан | Тайлан | Рифампицинд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний бүртгэл (ЭТС-1А) маягтад суурилан улирал тутам энэ тайланг гаргана.<br>Тухайн улиралд бүртгэгдсэн болон эмчилгээ эхэлсэн Рифампицинд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдлын тоог тодорхойлолтын дагуу тохирох нүдэнд бичнэ.<br>Эмчилгээ эхэлсэн тохиолдлыг нас, хүйсээр ангилж бичнэ. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| ЭТС-7Б | Нэг болон цөөн Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй (Рифампицинаас бусад) өвчтөний улирлын тайлан | Тайлан | Нэг болон цөөн Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний бүртгэл (ЭТС-1Б) маягтад суурилан улирал тутам энэ тайланг гаргана. Тухайн улиралд бүртгэгдсэн болон эмчилгээ эхэлсэн нэг болон цөөн ЭТС-ийн тохиолдлын тоог тодорхойлолтын дагуу тохирох нүдэнд бичнэ.<br>Эмчилгээ эхэлсэн тохиолдлыг нас, хүйсээр ангилж бичнэ. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| ЭТС-8А | Рифампицинд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдлын эмчилгээний үр дүнгийн тайлан | Тайлан | ЭТС-1А маягтанд үндэслэн тайланг гаргана. 24 сарын өмнөх тухайн улиралд бүртгэгдсэн өвчтөний эмчилгээний үр дүнгийн тайлан.<br>24 сарын өмнө эмчилгээ эхэлсэн тохиолдлын (ЭТС-7А) тайланд үндэслэн үр дүнгийн тайланг гаргана.<br>Улирлаар гаргаж, ХӨСҮТ-ийн СТСА-нд мэдээлнэ. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ЭТС-8Б | Нэг болон цөөн Эмэнд тэсвэртэй сүрьеэтэй (Рифампици-наас бусад) өвчтөний эмчилгээний үр дүнгийн тайлан | Тайлан | Нэг болон цөөн эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээ эхэлснээс хойш тухайн улиралд (тайлант хугацаанд) тохирох 12-15 сарын өмнө эмчилгээ эхэлсэн тохиолдлын үр дүнг тохирох нүдэнд гаргана.<br>Мөн улирлаар тайланг гаргана. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| ЭТС-9А | Рифампицинд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөний эмчилгээний 6 дахь сарын үр дүнгийн тайлан | Тайлан | Рифампицинд тэсвэртэй эмчилгээ эхэлсэн тохиолдлуудын эрчимт эмчилгээний 6 дахь сард сөрөгт шилжсэн байдал болон эмчилгээний явцын бусад үр дүнг үнэлнэ. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| ЭТС-9Б | Нэг болон цөөн эмэнд тэсвэртэй (Рифампици-наас бусад) сүрьеэтэй өвчтөний эмчилгээний 3 дахь сард сөрөгт шилжсэн байдал | Тайлан | Нэг болон цөөн эмэнд тэсвэртэй тохиолдлын эмчилгээний явцад сөрөгт шилжилтийн байдлыг энэхүү тайланд үндэслэн үнэлнэ. Нэг болон цөөн (ЭТС-1Б) маягтанд тулгуурлан тайлан гаргана. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| ЭТС-10 | Эмэнд тэсвэртэй сүрьеэ байж болзошгүй тохиолдлын бүртгэл | Бүртгэл | ЭТС-тэй байж болзошгүй тохиолдлыг уг маягтад бүртгэнэ. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |
| ЭТС-11 | Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн хавьтлын бүртгэл, хяналт | Бүртгэл | Сүрьеэгийн эмч нар тохиолдол бүрт хөтөлнө. | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч |

### 1.5. Мэдээний чанарын хяналт

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, цаашид гарах зөвлөмжид хамгийн их нөлөөлөх онцгой ач холбогдол бүхий зүйл бол мэдээ, мэдээллийн чанарын асуудал юм. Мэдээний чанарыг үнэлэх дараах шалгуур үзүүлэлтүүд байгаа. Үүнд:

**Шуурхай байдал:** Мэдээг цаг хугацаанд нь цуглуулж дараагийн түвшинд мэдээлэх.

**Давтамж:** Мэдээ цуглуулах хоорондын зай нь тодорхой бөгөөд баталгаат, олон улсын стандартад нийцсэн байх.

**Зохицсон байдал:** Мэдээнүүд хоорондоо болон цаг хугацаатай нийцсэн эсэх, тогтмол, ил тод хуваарийн дагуу мэдээг шинэчлэн мэдээлдэг эсэх.

**Төлөөлөх чадвар:** Мэдээ нь хүн ам буюу хүн амын тодорхой бүлгийг зохих ёсоор төлөөлж чадаж буй эсэх.

**Тооцоолох аргачлал ба статистикийн аргууд:** Мэдээ нь шаардлагатай байдлаар тухайлбал: нас, хүйс, нийгэм, эдийн засгийн байдал, засаг захиргааны буюу газарзүйн нэгж, яс, үндэс зэргээр шалгуур үзүүлэлтийн задаргааг гаргах боломжтой эсэх.

Чанартай мэдээ цуглуулж байж үнэн зөв мэдээлэлд үндэслэсэн оновчтой зөв шийдвэр гаргана. Бид мэдээг хэрхэн зөв, цаг хугацаанд нь авч хариу арга хэмжээг зөв төлөвлөж, зөв хэрэгжүүлж чадна түүнд л мэдээллийн анхдагч үнэ цэнэ оршдог.

Стандарт аргачлалын дагуу мэдээний аудитыг тогтмол хийх нь мэдээний чанарыг сайжруулж, явцын дунд тохиолдсон бэрхшээл, дутагдлыг илрүүлэн засч залруулахад дэмжлэг болдог.

Мэдээний чанарыг мэдээг цуглуулах, дамжуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, түгээх бүх шатанд хянах нь чухал. Мэдээний чанарын үнэлгээг дараах хоёр хэлбэрээр хийж болно. Үүнд:

**Хөндлөнгийн хяналт** - гадны шинжээч болон гадны баг томилж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг хөндлөнгөөс нь үнэлэх

**Байнгын буюу дэмжлэгт хяналт** - байгууллага дотооддоо буюу тухайн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж байгууллагууд өөрсдөө буюу дотооддоо шинжээчийн баг томилон тодорхой давтамжтайгаар хийх.

### 1.6. Мэдээллийн төрөл, мэдээллийн түгээлт ба хэрэглээ

Сүрьеэ өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, боловсруулалт хийж, Хүснэгт 19-д дурьдсан мэдээллийн төрлийг боловсруулан хэрэглэгчдэд түгээж, бодлого боловсруулах, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр ханган ажиллана.

Хүснэгт 19. Мэдээллийн төрөл ба түгээлт

| № | Мэдээллийн төрөл | Давтамж | Түгээх хэлбэр | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|
| 1 | Сүрьеэгийн өвчлөл, нас баралтын мэдээ | Сар, улирал, жил бүр | Товхимол, Үндэсний мэдээний сан, цахим хуудас | ХӨСҮТ, ЭМХТ, ЭМЯ |
| 2 | Тусламж, үйлчилгээний хамралтын тайлан | Сар, улирал, жил бүр | Цахим хуудас | ХӨСҮТ, Глобаль сан |
| 3 | Сүрьеэгийн тархвар судлалын тайлан | Жил бүр | Үндэсний мэдээний сан | ЭМЯ, ХӨСҮТ |
| 4 | Сүрьеэгээс сэргийлэх үйл ажиллагааны жилийн тайлан | Жил бүр | Үндэсний мэдээний сан | ХӨСҮТ |
| 5 | ХДХВ-ийн тусламж, үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй болгох зорилтын хэрэгжилтийн тайлан | Жил бүр | Үндэсний мэдээний сан | ЭМЯ, ХӨСҮТ |
| 6 | Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал-2030, Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийн тайлан | Явцыг жил бүр, хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 жил тутам | Үндэсний мэдээний сан, цахим хуудас | ЭМЯ, ХӨСҮТ |
| 7 | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан | Явцыг жил бүр, хяналт-шинжилгээ, үнэлгээг хөтөлбөрийн дунд хугацаанд, төгсгөлд | Үндэсний мэдээний сан, цахим хуудас | ЭМЯ, ХӨСҮТ |
| 8 | Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийн тайлан | Явцыг жил бүр, хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 жил тутам | Үндэсний мэдээний сан, цахим хуудас | ЭМЯ, ХӨСҮТ |
| 9 | Сүрьеэгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой гарсан тушаал, шийдвэрийн хэрэгжилтийн тайлан | Тухай бүр | Үндэсний мэдээний сан, цахим хуудас | ЭМЯ, ХӨСҮТ |
| 10 | Бусад үнэлгээ, судалгааны ажлын тайлан | Тухай бүр | Танилцуулах уулзалт, хэвлэмэл үнэлгээ, судалгааны тайлан, Үндэсний мэдээний сан, цахим хуудас | Гүйцэтгэсэн байгууллага, санхүүжүүлэгч байгууллага, ЭМЯ |

Эрүүл мэндийн сайдын 2020 оны ...12 сарын
20...-ний өдрийн А/... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## 1.7. Сүрьеэ өвчнөөс сэргийлэх хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө (2020-2021 он)

| № | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Хэрэгжүүлэх байгууллага | | Хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Үндсэн | Хамтрагч | 2020 | 2021 |
| *Бүрэлдэхүүн 1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр* | | | | | | |
| 1 | Маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээний үр дүнг дагаж судлах, үр дүнг тооцох | 2020-2021 | ХӨСҮТ | Глобал сан | - | Судалгааны тайланг хүлээлгэн өгсөн байна |
| 2 | Интерферон гамма аргаар сүрьеэгийн халдварыг илрүүлэх аргыг нэвтрүүлэх | 2020 | ХӨСҮТ | Глобал сан | Судалгааны тайланг хүлээлгэн өгсөн байна | - |
| 3 | Олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн богино хугацааны эмчилгээг үе шаттайгаар нэвтрүүлэх | 2020-2021 | ХӨСҮТ | Глобал сан<br>ДЭМБ | - | Эмчилгээ бүрэн нэвтэрсэн байна. |
| *Бүрэлдэхүүн 2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр* | | | | | | |
| 4 | Тархвар судлал болон сүрьеэгийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ашиглах талаар эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтад хамруулах | 2020-2021 | ХӨСҮТ | Аймаг, дүүргийн ЭМГ, БОЭТ<br>ДЭМБ | Удирдамж, хөтөлбөр<br>Оролцогчдын тоо<br>Тайлан | Удирдамж, хөтөлбөр<br>Оролцогчдын тоо<br>Тайлан |
| 5 | Нэгж байгууллагын статистик, бүртгэл мэдээлэл хариуцсан эмч, мэргэжилтэнд зориулсан сүрьеэгийн бүртгэл, | 2020-2021 | ЭМХТөв | ХӨСҮТ | Удирдамж, хөтөлбөр<br>Оролцогчдын тоо | Удирдамж, хөтөлбөр<br>Оролцогчдын тоо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийн сургалтыг тогтмол зохион байгуулах | | | | Тайлан | Тайлан |
| 6 | Аймаг, дүүргийн сүрьеэгийн эмч нарт эрүүл мэндийн анхан шатны байгууллагад дэмжлэгт хяналт хийх чиглэлээр чадавхижуулах сургалт зохион байгуулах | 2020-2021 | ХӨСҮТ | Глобаль сан | Удирдамж, хөтөлбөр Оролцогчдын тоо Тайлан | Удирдамж, хөтөлбөр Оролцогчдын тоо Тайлан |
| *Бүрэлдэхүүн 3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг тогтмолжуулах тогтвортой байдлыг хангах чиглэлээр* | | | | | | |
| 7 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүр явцын хяналт хийх | 2020-2021 | ЭМЯ, ХШҮДАГ | - | Явцын тайлан | Явцын тайлан |
| 8 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх үнэлгээ хийх | 2021 | ЭМЯ, ХШҮДАГ | ЭМХТ Олон улсын байгууллага | - | Тайлан гарсан байна. |
| 9 | Иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог дэмжих, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор үнэлгээ хийх | 2020 | ЭМЯ, ХНХЯ, ХӨСҮТ | ТББ, ОУБ | Хамрагдсан байгууллагын тоо, үнэлгээний дүн | - |
| *Бүрэлдэхүүн 4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн эх сурвалжийг нэмэгдүүлэх чиглэлээр* | | | | | | |
| 10 | Бүртгэл, мэдээллийн цахим системийг цаашид хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах | 2020 | ХӨСҮТ | ЭМХТөв | | |
| *Бүрэлдэхүүн 5. Бодлого, хөтөлбөрийн тогтмол хяналт, үнэлгээг сайжруулах чиглэлээр* | | | | | | |
| 11 | Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | 2020-2021 | ЭМЯ | ХӨСҮТ | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна. | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 12 | Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | 2020-2021 | ЭМЯ | ХӨСҮТ | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. |
| 13 | “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөриийн хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | 2020-2021 | ЭМЯ | ХӨСҮТ | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна. | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. |
| *Бүрэлдэхүүн 6. Үндэсний болон орон нутгийн мэдээний сан бүрдүүлэх, бэхжүүлэх чиглэлээр* | | | | | | |
| 14 | Эмэнд тэсвэртэй сүрьеэгийн мэдээллийн санг үүсгэж үйл ажиллагаанд хэрэглэх | 2020-2021 | ХӨСҮТ | ЭМХТөв | Мэдээллийн сангийн баяжилт | Мэдээллийн сангийн баяжилт |
| *Бүрэлдэхүүн 7. Дэмжлэгт хяналт ба мэдээний чанарын хяналтын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр* | | | | | | |
| 15 | Сүрьеэгийн бүртгэл, мэдээллийн чанарын үнэлгээг тогтмол хийх | 2020-2021 | ХӨСҮТ | Аймаг, дүүргийн ЭМГ, БОЭТ<br>Глобал сан | Үнэлгээний тайлан | Үнэлгээний тайлан |
| 16 | Дэмжлэгт хяналтын явцад мэдээллийн чанарыг шалгах байдлыг сайжруулах гарын авлага боловсруулах | 2020 | ХӨСҮТ | ДЭМБ | Гарын авлага | - |
| 17 | Тандалтын тоон мэдээ болон тайлангийн чанартай холбоотой эргэн мэдээллийг | 2020-2021 | ХӨСҮТ | ЭМХТөв | Эргэн мэдээллийн тоо | Эргэн мэдээллийн тоо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | нэгж байгууллагад тогтмол хүргэх | | | | | |
| *Бүрэлдэхүүн 8. Мэдээллийн түгээлт ба хэрэглээг сайжруулах талаар* | | | | | | |
| 18 | Тайлан мэдээ гаргах чиглэлээр онлайн гарын авлага боловсруулж нэгж байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангах | 2020 | ХӨСҮТ ЭМХТөв | Аймаг, дүүргийн ЭМГ, БОЭТ | Онлайн гарын авлага Байгууллагын тоо | Байгууллагын тоо |
| 19 | Үндэсний болон орон нутгийн хэмжээн дэх шийдвэр гаргагчдын уулзалтад хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг танилцуулах | 2020-2021 | ЭМЯ | ХӨСҮТ Аймаг, дүүргийн ЭМГ, БОЭТ | Уулзалтын тайлан | Уулзалтын тайлан |
| 20 | “Сүрьеэгийн тандалтын мэдээний эмхэтгэл” жилийн тайлангийн номыг эмхэтгэн хэвлүүлж мэргэжлийн байгууллагад хүргэх | 2020-2021 | ХӨСҮТ | ЭМХТөв | Тайлангийн ном | Тайлангийн ном |
| 21 | Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг цахим хуудас, мэргэжлийн сэтгүүлд тавих | 2020-2021 | ХӨСҮТ | ЭМХтөв Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүлийн редакц | Цахим хуудас, сэтгүүлд тавигдсан мэдээлэл | Цахим хуудас, сэтгүүлд тавигдсан мэдээлэл |
| 22 | Үндэсний болон орон нутгийн хэмжээн дэх мэдээллийн чанар, тархвар судлал, бүртгэл мэдээлэлийн асуудлыг хэлэлцэх бүсчилсэн зөвлөгөөнийг зохион байгуулах | 2021 | ЭМЯ | ХӨСҮТ Аймаг, дүүргийн ЭМГ, БОЭТ | - | Уулзалтын тайлан |

---ooOoo---